



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗАР

Нийслэлийн засаг захиргааны IV байр,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160-0066
Утас:(976) 7575 7807, Факс: (976) 7575 7809
Цахим шуудан: contact@ub-procurement.mn
Цахим хаяг: www.ub-procurement.mn

2024.08.21 № 03/1608

танай _____-ны № _____-т

Тодруулга оруулах тухай

Тус газраас 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдөр зарласан Нийслэлийн үнэт цаасны хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх НХААГ/20240101536 дугаартай Гүнтийн авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Шаргаморьтын уулзвараас Гүнтийн даваа хүртэл)-ийн ажлын магадлал хийгдсэн зураг, төсвийг захиалагчийн хяналт тавих байгууллагаас ирүүлсэн тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6 дахь заалтын дагуу Тендер шалгаруулалтын баримт бичигт дараах өөрчлөлтийг оруулж байна. Үүнд:

№	Тендер шалгаруулалтын баримт бичгийн заалт	Орсон өөрчлөлт
1.	Тендер шалгаруулалтын баримт бичиг дэх өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1 дэх заалт: 3.Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлага: “Шаардана” Тендерт оролцогчийн техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлага: Сүүлийн 3 жил буюу 2021, 2022, 2023 онуудын аль нэг жилд төсөвт өртгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлын үндсэн гүйцэтгэгчээр доод тал нь нэг удаа ажилласан байх гэснийг;	3.Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлага: “Шаардана” Тендерт оролцогчийн техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлага: Сүүлийн 3 жил буюу 2021, 2022, 2023 онуудын аль нэг жилд төсөвт өртгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлын үндсэн гүйцэтгэгчээр доод тал нь нэг удаа ажилласан байх. (2024 оны ижил төстэй ажлыг тооцно) гэж;
2.	Тендер шалгаруулалтын баримт бичиг дэх өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1 дэх заалт: .Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх шаардлага: “Шаардана” гэснийг;	4.Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх шаардлага: “Шаардана” Тендер шалгаруулалтад санал болгосон инженер техникийн ажилтан, машин механизмуудын 50-аас дээш хувь нь 70 хувиас бага гүйцэтгэлтэй авто замын ажилд давхацсан тохиолдолд тендерээс татгалзана. Давхцал үүсээгүй тухай албан мэдэгдэл ирүүлнэ гэж;
	Тендер шалгаруулалтын баримт бичиг	

3.	<p>дэх өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.2 дахь заалт: 4.Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээллийг нотлох баримт бичиг; а) Тендерт оролцогч нь өөрийн болон түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан ажлын гүйцэтгэлийн явцын талаарх мэдээллийг тус ирүүлнэ гэснийг;</p>	<p>4.Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээллийг нотлох баримт бичиг; а) Тендерт оролцогч нь өөрийн болон түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан ажлын гүйцэтгэлийн явцын талаарх мэдээллийг тус ирүүлнэ. (Захиалагчийн ажлын гүйцэтгэлийн явцын талаарх тодорхойлолт ирүүлнэ) гэж;</p>
4.	<p>Тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 26.1 дэх заалт: Тендер хүлээн авах эцсийн хугацаа 2024 оны 08 дугаар сарын 05-ны өдөр гэснийг;</p>	<p>Тендерийн хүлээн авах эцсийн хугацаа 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр гэж;</p>
5.	<p>Тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 26.2 дахь заалт: Тендерийн нээлт хийх хугацаа 2024 оны 08 дугаар сарын 05-ны өдөр гэснийг;</p>	<p>Тендерийн нээлт хийх хугацаа 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр гэж;</p>

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т заасны дагуу тодруулгыг цахим системд нээлттэй байршуулснаар сонирхогч этгээдэд хүргүүлсэнд тооцно.

Ажлын зураг төсвийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ийн "ТЭЗҮ" хэсгээс харна уу.